



1 1 дүгээр анги Нийгэм судлал

НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ

Америкийн судлаач Ө.Күүс 1990-ээд онд нийгэм-эдийн засгийн ялгаа бүхий гурван ангийн хүмүүс өөрсдийн өвчний шинж тэмдгийг хэрхэн тайлбарладаг болохыг судалжээ. Тэрээр

- 1) Эдийн засаг, санхүүгийн хувьд хамгийн амжилттай байгаа**
- 2) Цалингаараа амьдардаг дундаж хэсгийнхнийг**
- 3) Ур чадвараар бага, даржин амьдралтай хэсгийнхнийг багтаан судалсан байна.**

Нэг дэх ангийн хүмүүс өвчний нэг шинж тэмдэг илрэхэд эмчид хандаж эрүүл мэндийн үйлчилгээ эрэлхийлэхэд бэлэн байсан бол харин гурав дахь ангийн хүмүүсийн 75 хувь нь өвчний 17 шинж тэмдгийн 10-ыг эмнэлэгт үзүүлэх ноцтой шинж биш гэж үзжээ. 2013 онд ЭМШУИС-иас хийсэн судалгаагаар бага орлоготой хүн ам, хөдөөгийн малчид, оюутан залуус эрүүл мэндийн үйлчилгээний бодит хэрэгцээ тулгарах үед эмнэлгээр үйлчлүүлдэг болох нь тогтоогджээ.

НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ



- ❖ Судлаач Ө. Күүсийн судалгаа нь ангийн ялгаа эрүүл мэндийн үйлчилгээ авах үйлдэл, хандлагын ялгаанд хүргэдэг болохыг нотолсон олон судалгааны эхлэл болсон.
- ❖ Социологич Д. Датон ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ бага эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа нь санхүүгийн боломж, ядуусын соёл, нийгмийн институтийн саад бэрхшээлтэй холбоотой гэж дүгнэсэн.

НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ


Ямар байр суурь эзэлж байгаагаасаа хамааран шийдвэр гаргахад оролцох боломжоор нийгмийн гишүүд харилцан адилгүй байна



Ямар байр суурь эзэлж байгаа нь цалин хөлс, орлогын хэмжээнд нөлөөлж байна.



НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ



НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ

Ямар байр суурьт хүрэх вэ гэдэг нь хувийн болон институтийн хүчин зүйлсээс хамаардаг.



Авьяас чадвар, хичээл зүтгэл, шаргуу хөдөлмөр гэсэн хувийн хүчин зүтгэлээс хамаарч байна.



Өсч торнисон гэр бүл, сурч боловсрох сургуулийн орчин нь түүнийг авьяасаа хөгжүүлэх, ашиглах боломжийг олгоогүй.

НИЙГМИЙН ДАВХРААЖИЛТ

Нийгмийн ялгарал	Нийгмийн гишүүд хувийн нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдахыг хэлнэ.
Тэгш бус байдал	Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх адил бус боломж бүхий байдлыг хэлнэ.
Нийгмийн давхраажилт	Тодорхой хэв шинжит харилцаа бүхий тэгш бус байдлын тогтолцоо
Нийгмийн давхраа	Баялаг, нэр хүнд, эрх мэдлийн хувьд ялгаатай, тодорхой хэв шинжит харилцаа бүхий нийгмийн нийтлэг
Нийгмийн нийтлэг	Ижил төстэй шинж бүхий хүн амын статистик нэгдэл

